



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 5/91

Улаанбаатар хот

Үр дүнгийн урамшуулал олгох тухай


Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь заалтууд, 46 дугаар зүйлийн 46.4 дэх заалт, "Төрийн албаны тухай" хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, 2013 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн үр дүнгийн гэрээг дүгнэн хэлэлцсэн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2013 оны ажлын үр дүнг дүгнэж, үр дүнгийн гэрээний биелэлтээр албан хаагчдад олгох урамшууллын хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. 2013 онд ажлын үр бүтээлтэй ажиллаж байгаа нягтлан бодогч П.Ариунаа, нярав Г.Цэрэннадмид нарт тус бүр нэг сарын цалингийн урамшуулалыг хоёрдугаар хавсралт ёсоор олгосугай.

3. Урамшуулалд зарцуулах нийт 6,240,882 /зургаан сая хоёр зуун дөчин мянга найман зуун наян хоёр/ төгрөгийг урьд оны төсвийн хэмнэлт болон нэг удаагийн тэтгэмж, урамшуулалын зардлаас гаргаж, хавсралтад заасан хувь хэмжээгээр албан хаагчдад бодож олгохыг нягтлан /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН